



### Мэндчилгээ

2020-2022 онуудад даяарыг хамарч, Монголыг маань ч нэрвэсэн цар тахлын улмаас хэсэг завсарласан “Бодлогын судалгааны төв”-ийн үйл ажиллагаагаа бид сэргээж, манай сургуулийн бас нэг брэнд бүтээгдэхүүн нэгэнтээ болсон “Бодлогын мэдээ”-гээ үргэлжлүүлэн гаргах болж байна.

Энэ нь, нэг талаас, сүүлийн үед олон улсын байдал эрс доройтож үнэхээр VUCA (volatile, uncertain, complex, ambiguous) болсон, нөгөө талаас, МУИС-ийг бүхэлд нь, түүний дотор манай сургуулийг эрдэм шинжилгээ, судалгааны чиглэлээр хөгжүүлэх шаардлага өндөрсөж, уг ажил эрчимжиж байгаатай холбоотой юм.

“Бодлогын судалгааны төв”-өөр дамжуулан олон улсын харилцаа, гадаад бодлого, аюулгүй байдлын судлаач, шинжээчдийн хамтын ажиллагааг хөхиүлэн дэмжих, улмаар нийгмийн өргөн хүрээтэй тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэхэд чиглэсэн бодлогын судалгааг хөгжүүлэх, сургалт-судалгааны симбиозыг дээшлүүлэх үйлсэд үнэтэй хувь нэмэр оруулахыг хүсэн хүлээж байна.

Монгол улсын Гадаад бодлогын үзэл баримтлалд тодорхойлсон “Гадаад бодлогын нэгдмэл байдлыг хангах, залгамж чанарыг хадгалах”-аар Монголын улс төрийн хүчнүүд хэзээд нэгдмэл байр суурьтай байж ирсэн, үндэсний хэмжээнд бэлтгэж буй гадаад харилцааны мэргэжилтнүүдэд улс төрөөс ангид, улс төржсөн мэдлэг олгохоос татгалзаж ирсэн уламжлалаа жижиг улсын хувьд Монгол улс хадгалахыг чармайх нь зүйтэй.

Монгол улсын гадаад харилцаа өдрөөс өдөрт өргөжин тэлж, өндөр мэдлэг чадвартай, үндэсний боловсон хүчин шаардлагатай байгаа нөхцөлд ОУХНУС-ийн өөрийн онцлогийг нь харгалзан бүтцийг нь тодорхойлж буй Бодлогын судалгааны төв нь жижиг улсын гадаад бодлого, гадаад харилцааны сургалт судалгааны дүр төрх болгон хөгжүүлэх нь Монгол улсын үндэсний язгуур эрх ашигт илүүтэй нийцнэ.

Энэ нь жижиг улсын гадаад бодлогын залгамж чанарыг хадгалах, өдрөөс өдөрт өргөжин тэлж буй даяаршсан Монгол улсын гадаад харилцаа болон төрийн удирдлагын эрэлт шаардлагад тус тус нийцсэн, МУИС-ийн баримталж буй стратегийн хүрээнд Азид хүлээн зөвшөөрөгдсөн их сургууль болох шаардлагад нийцэж буй эхлэл гэж бид үзэж байна.

“БСТ”-ийнхөө үйл ажиллагааг бүх талаар дэмжиж идэвхтэй оролцож байхыг нийт багш-судлаач, оюутан залуусдаа уриалж байна.

ОУХНУС-ийн захирал Ж.Баттогтох

# ОЛОН УЛСАД

Эдүгээ жил гаруй үргэлжилж, хэзээ төгсөх нь үл үзэгдэх Орос-Украины дайн олон улсын харилцааны уур амьсгал, цаашдын чиг хандлагыг эрс өөрчлөн даяарын хэмжээнд хор уршиг дагуулж байгаа билээ. Энэ дайн олон чиглэлээр, түүний дотор манай бүс нутаг, Монгол Улсын аюулгүй байдлын гадаад орчинд ч сөргөөр нөлөөлсөөр байна.

МУИС-ОУХНУС-ийн дэргэдэх Бодлогын судалгааны төв, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн дэргэдэх Стратегийн судалгааны хүрээлэн хамтран “Орос-Украины мөргөлдөөн: Дэлхийн шинэ дэг журам болон Монгол Улсын анхаарах асуудлууд” сэдэвт хэлэлцүүлгийг 2023 оны 3 дугаар сарын 3-ны өдөр зохион байгуулав. Хэлэлцүүлэгт тус хоёр байгууллагын багш, судлаачид болон аюулгүй байдал, гадаад

бодлогын асуудлаар мэргэшсэн бусад шинжээч, судлаачид өргөнөөр оролцсон болно.

Бид “Бодлогын мэдээ” сэтгүүлээ сэргээхдээ уг хэлэлцүүлгийн материалаас дугаар дамжуулан нийтэлж, уншигч олныхоо анхааралд хүргэхээр шийдэв. Энэ удаа илтгэл бэлтгэж оролцсон 4 судлаачийн яриг дор сийрүүллээ. Болгооно буй заа.

Х.Бэхбат





С.Баясгалан

ОУХНУС-ийн дэд профессор

## ОРОС-УКРАЙНЫ МӨРГӨЛДӨӨН БА ДЭЛХИЙН ГЕОПОЛИТИКИЙН ХУВЬСАЛ, ӨӨРЧЛӨЛТ

“Хүйтэн дайн” дууссанаас хойш АНУ-г ямар өнцгөөс нь харахаас хамаараад ноёрхож, манлайлж, жанжлаж байна гэх зэргээр тодорхойлж ирсэн билээ. Хятадыг харвал үндсэндээ 1978 оноос алхам алхамаар хүчирхэг болж эхэлсэн. Өнөөдрийн хөгжил болоод АНУ-тай мөчөөрхөх хэмжээнд эдийн засаг, шинжлэх ухаан, технологийн салбар хөгжиж эхэлсэн үе нь 2001 онд ДХБ-д элссэнээс хойш гэж үзэж болно. Хятад эдийн засгаа хөгжүүлэхийн тулд чөлөөт бүс-хотуудыг байгуулж, барууны компаниуд болон эрдэмтэн, судлаачидтай хамтран ажиллах замаар шинжлэх ухааны дэвшилээ түргэтгэж, техник технологийн ололтыг хүртэж чадсан. Хэдийгээр олон салбарт АНУ болон барууны орнуудын хэмжээнд хүрэх болоогүй байгаа ч мэдээлэл, технологийн салбарт зэрэгцэн очоод байна.

Оросын хувьд гэвэл 2000 онд В.Путин засгийн эрхэнд гарснаас хойш даагаа нэхэх маягаар явж иржээ. В.Путин өөрөө ЗХУ-ын задралыг геополитикийн асар том ухралт, том алдаа болсон гэж үздэг ба үүнд М.Горбачевийг буруутгадаг. АНУ болон барууны орнууд Оросыг үл тоож байна, Оросын санал бодлыг авч хэлэлцэхгүй байна, бид нарын үгийг сонсдог, тооцдог болно гэж тэрээр байнга үглэдэг болсон. Тэгээд ч сүүлийн жилүүдэд хүчтэй Евразист бодлого явуулж ирлээ.

Дотоод бодлогын хувьд В.Путин бүрэн эрхийнхээ хугацаанд Оросын эдийн засгийг хөгжүүлэх, гаднаас аль болох хараат бус болгохыг бүх талаар эрмэлзэж иржээ. Аливаа дайн тулаан, бүс нутгийн зэвсэгт мөргөлдөөн, эдийн засгийн онцгой нөхцөл байдлын үед эдийн засгаа тогтвортой байлгах зорилгоор алтны нөөц хуримтлуулах зорилгоор шат дараалсан алхмуудыг хийсний дүнд нийт нөөц нь 600 орчим тэрбум ам.доллартай тэнцэх хэмжээнд хүрчээ. 2014 онд Крымиг авснаас хойш Европын орнууд эдийн засгийн хориг тавьж эхэлсэн. Оросууд хариу арга хэмжээ авч, эрүүл мэндийн шаардлага хангахгүй байна гэх шалтгаар Роспотребнадзор Европоос орж ирсэн хүнсний бүтээгдэхүүнийг устгалд оруулж байлаа. Үүний зэрэгцээ импортыг орлох тал дээр шат дараатай арга хэмжээ авч, татварыг хөнгөлж, өрийг нь хааж, санхүүгийн дэмжлэг үзүүлж байв. Гэвч 2022 гэхэд Украины дайнд нөлөө үзүүлэх гадаадаас хамааралтай зарим үйлдвэрлэлийн салбартаа бүрэн шинэчлэл хийж хараахан чадаагүй байжээ. Үүнд өндөр технологи, сансар огторгуй, машин механизм зэрэг салбарын дэвшилт технологийг хэлж байна. Тухайлбал, тийрэлтэт хөдөлгүүр болон иргэний зориулалттай нисэх онгоцны хөдөлгүүр зэрэг эдийн засгийн хоригт орсны улмаас тасалдаад байгаа эд ангиудыг хараахан үйлдвэрлэж чадахгүй байна.

Дээр өгүүлснийг товчлон дүгнэхэд, дэлхийн хоёрдугаар дайнаас хойш эдийн засгийн хувьд ч, технологийн хувьд ч АНУ дэлхийн хөгжлийг манлайлсан хэвээр, харин ЗХУ-ын задралаар хүчээ алдсан Орос дахин сэхэхийг оролдож, 1978 оноос чөлөөт эдийн засаг руу орсон Хятад шинжлэх ухаан-технологийн талаар АНУ-ын түвшинд тулж ирснээр дэлхий олон туйлт тогтолцоонд шилжих эхлэл тавигдсан гэж үзэж болох юм.

ОУХ-ны судлаач Меаршаймерын хэлдгээр “ер нь юм байрандаа байдаггүй. Нэг тэнцвэр тогтсон ч гэсэн дараа нь өөр улс хүчтэй болж ирвэл өмнө нь тогтсон тэнцвэр, тоглоомын дүрэмд сорилт болж, тоглоомын дүрмийг шинээр тогтоохыг хүсдэг”.

Энэ өнцгөөс харвал Орос, Хятад хоёр АНУ-ын “жанжлах” бодлогыг бүх талаар сөрөх арга хэмжээ авч байна. Юуны өмнө долларыг орон зайн хувьд шахах замаар АНУ-ыг сулруулж, батлан хамгаалах хүчин чадавхид нөлөөлөх оролдлого ажиглагдаж байна. Орос, Хятад хоёр олон туйлт тогтолцооны төлөө байгаа, энэ байр суурийг хамтдаа ч олон удаа, янз бүрийн байдлаар илэрхийлж ирсэн байдаг.

Карл фон Клаузевиц “Дайн гэдэг бол аливаа улсын явуулж буй бодлогын зөвхөн нэг инструмент, арга хэрэгсэл” гэж хэлжээ. Өөрөөр хэлбэл улс төр-дипломатын яриа хэлэлцээ үр

дүнд хүрэхгүй байвал дараагийн буюу эцсийн арга хэмжээ нь дайн юм. Дайн бол өөрөө геополитикийн нэг том тоглолт мөн. Өнөөдөр ч гэсэн энэ үзэл санаа, их гүрнүүдийн явуулдаг гадаад бодлогын энэ хэлбэр үеэ өнгөрөөгөөгүй байгааг та бид харж байна.

Орос-Украины дайн дуусах уу, үгүй юу гэсэн асуултанд хариулахын тулд дараах зүйлийг хэлмээр байна. Дайн өөрөө их барьцгүй асуудал. Жишээ хэлэхэд, Вестфалийн гэрээ байгуулагдахаас өмнөх дайн 30 жил үргэлжилнэ гэж бодож байсан болов уу, үгүй болов уу гэдэг их сонин асуулт, ямарч байсан удаан үргэлжлэхгүй гэж бодож байсан байх. Өөр нэг жишээ бол дэлхийн 1-р дайн байна. Европын гүрнүүд хурдан асуудлаа шийдээд болно гэж бодсон байх. Гэвч хүч тэнцсэнээс болоод дайн сунжирсан. Сүүлд нь АНУ дайнд Антантын талд орсноор холбоотнууд ялагдсан байдаг. Ийм жишээ олон бий, дундаа завсарлагатай 100 жилийн, 70 жилийн дайнууд ч байсан. Эдгээр дайнууд үндсэндээ их гүрнүүдийн нөөц чадавхи барагдаж байж дуусдаг аж. Энэ өнцгөөс авч үзвэл Украины дайн сунжрах төлөвтэй байна. Бүс нутгийн, эсвэл хоёр овог аймаг, улс орон хоорондын дайн хүчний тэнцвэр хангагдаад, зөвшилцөлд хүрч, найрамдаж байж дуусдаг. Харин их гүрнүүдийн хоорондын дайн бол үзэл санаа, соёл иргэншил, оюун санаа, итгэл үнэмшил, нийгмийн үнэт зүйлийн дайн болж байдаг учраас Украины дайн тийм амар шийдэгдэхгүй нь лавтай. Оросын талаас “Барууныхан Оросыг задлахыг хүсэж, Оросын аюулгүй байдалд аюул занал учруулж байна” гэсэн өнцгөөс хандаж байхад НАТО-гийн зүгээс барууны үнэ

цэнэ, ардчиллыг хамгаалах ёстой гэсэн байр сууринаас хандаж байна.

Орос, Украины дайнаас үүдэн гарсан уршиг дагаваруудаас харвал:

1. Их гүрнүүд буюу НҮБ-ын Аюулгүйн зөвлөлийн байнгын 5 гишүүний хувьд ашиг сонирхол нь нэн тэргүүнд явж байгаа учраас дэлхийн дэг журам хамаагүй гэсэн муу жишиг тогтож байна. Жижиг улсуудын аюулгүй байдал хэрхэх вэ гэдэг асуулт гарч ирнэ. НҮБ, олон улсын эрх зүй, олон улсын дэг журам бол жижиг улсуудын аюулгүй байдал, тусгаар улсын хил хязгаарын халдашгүй дархан байдлыг сахин хамгаална гэсэн нийтлэг үнэт зүйлийг зөрчиж байгаа учраас зэвсэгтэй найдах уу, холбоотон болж зэвсэглэх үү зэрэг асуултууд гарч ирж байна.

2. Улс орнууд батлан хамгаалах зардлаа нэмж байна. Ялангуяа барууны улсууд АНУ-д аюулгүй байдлын асуудлаа даатгаад, хөрөнгө юугаа эдийн засаг, нийгэм, хүмүүнлэг, шинжлэх ухаан технологи хөгжүүлэхэд зарцуулдаг байсан бол одоо батлан хамгаалах руугаа түлхүү гаргах шаардлагатай болж байна. Баян орнууд бол ДНБ-ий 2%-аа батлан хамгаалах зардалд гаргахад нэг их асуудал байхгүй ч гэсэн тодорхой хэмжээнд боловсрол, соёл, шинжлэх ухааны салбаруудын зардлыг танах хэмжээ рүү очих байх. Тэгэхээр буурай хөгжилтэй, хөгжиж буй, төлбөрийн чадваргүй орнууд яах вэ гэдэг асуудал гарч ирж байгаа.

3. Нөгөө талаар батлан хамгаалах аж үйлдвэр шинэ шатанд орохоос өөр замгүй болж байна. Ялангуяа зэвсгийг машин үйлдвэрлэж байгаа юм

шиг массаар, байнга үйлдвэрлэх хэмжээ рүү орж байна. Цаашилбал, хангамж буюу ложистикийн асуудал гарч ирж байгаа. Сүүлийн үеийн зэвсэг техникүүд өндөр технологитой болсон учраас түүнийх нь арыг хангах ложистик хэрэгтэй, нүсэр дэд бүтцийн хэмжээнд очиж, зардал ихсэх шинжтэй болж байгаа.

Дайны эдийн засаг, технологийн салбарт ширүүн тэмцэл өрнөж байна. Сүүлийн үед шинээр гарч ирж буй хүчин зүйлүүд нь соёл иргэншил хоорондын мөргөлдөөнд улам их тос нэмж, дайн бүх фронтоор өрнөж байна. Энэ хүрээнд үзвэл Украины дайн тийм ч амар эцэс болохгүй нь гэсэн таамаг байна.

Гуравдагч ертөнцийн хувьд гэвэл, хүйтэн дайны үеийн эвсэлд үл нэгдэх хөдөлгөөнтэй адил нөхцөл байдал дахин ирж байна. Global South гэдэг ойлголт улам хүчтэй болох биз. Ер нь Америкийн Оростой хийж байгаа дайнд бид нарыг битгий хутгаж оролцуул, бид төвийг сахисан байдалтай байна гэсэн байр суурийг Европт ч бас нэлээн гаргах болж байна. Сүүлд Францын ерөнхийлөгч Макрон “Бид Global South буюу дэлхийн өмнөд хэсгийн улсуудын итгэл найдварыг алдах хэмжээнд очоод байгааг анхаарах хэрэгтэй” гэж хэлснийг санацгаая.



**Н.Энхбаяр**  
ССХ, судлаач:

## ДАЙН БА ОЛОН УЛСЫН САНХҮҮ-ЭДИЙН ЗАСГИЙН СОРИЛТУУДААС

Ковидын улмаас буурч байсан дэлхийн эдийн засаг 2022 онд аажмаар сэргэж байна. Гэвч Украины дайн, Өрнөдийн орнуудын зүгээс ОХУ, Беларусь улсын эсрэг тогтоосон хориг арга хэмжээ, эрчим хүчний болон үр тарианы үнийн өсөлтийн улмаас зарим улс орнуудын өсөлт удааших төлөвтэй байна.

Өнгөрсөн 2022 оны байдлаар дэлхийн нийт эдийн засгийн хэмжээ 100 гаруй их наяд ам.долларт хүрсэн гэж судлаачид, ОУБ-ууд тооцоолсон. Дэлхийн эдийн засагт АНУ, БНХАУ болон Европын Холбоо голлох байр суурийг эзэлж байна. Тухайлбал:

АНУ-ын ДНБ \$25.3 их наяд, БНХАУ-ын ДНБ \$19.9 их наяд, Европын Холбооны гишүүн орнуудынх \$20.0 орчим их наяд ам.долларт хүрч байна.

БНХАУ-ын эдийн засаг ковидын улмаас 2020 онд буурсан, өсөлтийн хурд нь саарсан, өнгөрсөн онд хүн амын тоо нь 1976 оноос хойш анх удаа буурсан үзүүлэлттэй гарсан. Энэ бүхний улмаас БНХАУ эдийн засгийн хэмжээгээр АНУ-г ойрын жилүүдэд гүйцэж түрүүлнэ гэсэн судлаачдын таамаглал өөрчлөгдөж, ойрын 20 орчим жилд АНУ дэлхийн тэргүүлэх эдийн засаг хэвээр үлдэх магадлалтай болж байна.

Геополитикийн эрсдэлийн улмаас өндөр хөгжилтэй болон хөгжиж буй зарим улс орнууд Батлан хамгаалах зардлаа

ихээхэн нэмэгдүүлж байна. Стокхолмийн Энх тайвны судалгааны хүрээлэнгээс (SIPRA. <https://www.sipra.org>) гаргасан судалгаанаас үзвэл 2022 онд дэлхий нийтийн батлан хамгаалах зардал анх удаа \$2.1 их наяд ам.долларыг давсан ажээ. Энэ нь 1996 оноос хойш дэлхий нийтийн батлан хамгаалах зардал бүхэлдээ 2 дахин өссөн гэсэн үг юм.

дэлхийн өмнөд хэсгийн улсуудын итгэл найдварыг алдах хэмжээнд очоод байгааг анхаарах хэрэгтэй” гэж хэлснийг санацгаая.


АНУ-ын Батлан хамгаалах салбарын зардал энэ 2023 онд

бүхэлдээ \$886.0 тэрбум ам.долларт хүрэхээр төлөвлөгдсөн.

Европын Холбооны гишүүн орнууд батлан хамгаалах зардлаа ДНБ-ний 2 хувьд хүргэх зорилтыг дэвшүүлээд байна. Мөн Япон, Өмнөд Солонгос, Австрали улс, Тайвань ч адил батлан хамгаалах зардлаа нэмэгдүүлэн баталсан.

Саяхан хуралдсан БНХАУ-ын 2 их хурлын явцад тус улсын батлан хамгаалах зардлыг энэ 2023 онд 7.2 хувиар нэмэгдүүлэхээр төлөвлөн батлаад байна. Өнгөрсөн 2022 онд мөн 7.1 хувиар нэмэгдүүлсэн.

### Global Military Spending



2022 Fact Sheet (for 2021)<sup>[1]</sup>  
SIPRI Military Expenditure Database<sup>[5]</sup>

Rank ↕	Country ↕	Spending (US\$ bn) ↕	% of GDP ↕	% of global spending ↕
	<b>World total</b>	<b>2,113</b>	<b>2.2</b>	<b>100%</b>
1	United States	801.0	3.2	38%
2	China <sup>[a]</sup>	293.0	1.7	14%
3	India	76.6	2.4	3.6%
4	United Kingdom	68.4	2.1	3.2%
5	Russia	65.9	3.1	3.1%
6	France <sup>[b]</sup>	56.6	2.0	2.7%
7	Germany	56.0	1.4	2.7%
8	Saudi Arabia <sup>[a][c]</sup>	55.6	6.6	2.6%
9	Japan	54.1	1.1	2.6%
10	South Korea	50.2	2.8	2.4%
11	Italy	32.0	1.5	1.5%
12	Australia	31.8	2.0	1.5%
13	Canada	26.4	1.3	1.3%
14	Iran	24.6	2.3	1.2%
15	Israel	24.3	5.2	1.2%
16	Spain	19.5	1.4	0.9%
17	Brazil	19.2	1.2	0.9%
18	Turkey	15.5	2.1	0.7%
19	Netherlands	13.8	1.4	0.7%
20	Poland <sup>[b]</sup>	13.7	2.1	0.6%

[https://en.wikipedia.org/wiki/List\\_of\\_countries\\_by\\_military\\_expenditures](https://en.wikipedia.org/wiki/List_of_countries_by_military_expenditures)

Өрнөдийн орнуудын зүгээс ОХУ-ын газрын тосны үнийн дээд хязгаарыг тогтоож, энэ оны 2-р сараас эхлэн Европын Холбооны гишүүн орнууд ОХУ-аас газрын тос, нүүрс худалдан авахгүй байх, шатдаг хийн импортыг ихээхэн бууруулахаар тогтоосон. Үүний улмаас ОХУ-ын төсвийн орлого эхний 2 сард 30 гаруй хувиар тасалдаж, төсвийн алдагдал нь ихээхэн нэмэгдэж байна.

Гадаад эдийн засгийн орчин, геополитикийн эрсдэл Монгол улсад хэрхэн нөлөөлж болзошгүй вэ.

Нэгд. Өрнөдийн орнуудын болон ОХУ-ын зүгээс тогтоосон хориг арга хэмжээний улмаас Европын улс орнуудаас ОХУ-ын нутгаар транзит ачаа тээвэрлэх боломжгүй болсон. Иймд Европын орнуудаас авах импортын ачаа барааг Турк болон Төв Азийн зарим улс орны нутгаар л дамжуулан авах боломжтой, энэ нөхцөлд тээвэрлэлтийн зардал, цаг хугацаа нэмэгдэх эрсдэлтэй болсон.

Хоёрт. Мөн Украины дайн, хориг арга хэмжээний улмаас Монгол улсын агаарын орон зайгаар дамжин өнгөрөх олон улсын нислэг эрс буурсан.

Гуравт. ОХУ-ын зүгээс Европын зах зээлд гаргаж байсан газрын тос, нүүрс, шатдаг хийг БНХАУ, Энэтхэг улсын зах зээлд илүү ихээр гаргах болсон. Өнгөрсөн 2022 онд ОХУ-аас БНХАУ-д 20.0 сая орчим тн коксжих нүүрс нийлүүлсэн гэсэн мэдээлэл байна. Цаашид ОХУ-аас БНХАУ-ын нүүрсний зах зээлд орон зайгаа нэмэгдүүлэх нь Монгол улсын нүүрсний экспортын орон зайг шахах эрсдлийг өсгөж байна.

Дөрөв. Монгол улс -ОХУ-ын хилийн боомтоор дамжих ачаа тээвэр, худалдаа эрс буурсан тул манай улсын импортын ачаа бараа бүхэлдээ Тяньжин, Замын -Үүд боомтоор дамжин орж ирэх ганцхан гарц үлдэж байна. Хэрэв цаашид Тайваний хоолойн зөрчлийн улмаас БНХАУ-АНУ-ын хоорондын зөрчил хурцадвал Бохайн булангаар дамжин өнгөрөх далайн тээвэрлэлт түр саатах, гацах, тээвэрлэлтийн өртөг зардал нэмэгдэх эрсдэлтэй.

Дүгнэлт:

Дэлхий нийтээр геополитикийн болон бусад шалтгааны улмаас бүхий л талын эрсдэл нэмэгдэж байгаа тул Монгол улсын хувьд эдийн засгийн өсөлтөө хадгалж, гадаад худалдааг эрсдэлд оруулалгүй авч үлдэхийн тулд:

1. Хилийн боомтын хүчин чадлын нэмэгдүүлэх, Тавантолгой-Гашуунсухайт, Зүүнбаян-Хангийн чиглэлийн төмөр замын холболтыг аль болох богино хугацаанд хийж гүйцэтгэх, ашиглалтад оруулах,
2. Нүүрсний экспортыг цаашид бууруулалгүй, өнгөрсөн 2022 онд хүрсэн түвшнээс бууруулалгүй хадгалахын тулд БНХАУ-ын худалдан авагч талтай худалдааны нөхцөлийн талаар сайтар ярьж ойлголцож

байх, түүхий эдийн биржийн худалдааны талаар БНХАУ-ын худалдан авагч компаниудтай сайтар ойлголцож ажиллах,

3. Замын Үүд-Эрээний ганц боомтод гадаад худалдааны томоохон хувь төвлөрч байгаа эрсдэлийг цаашид бууруулахын тулд Шивээхүрэн-Сэхэгийн боомтын дэд бүтцийг сайжруулах, Сэхэ боомтоор импортын ачаа бараа авах нөхцөлийг бүрдүүлэх, Шивээхүрэн-Даланзадгад чиглэлийн автозамыг засаж сайжруулах, өргөтгөх арга хэмжээг 2023-24 онуудад хэрэгжүүлэх,

4. Төмөр замын талаар баримтлах бодлогод тусгагдсан Даланзадгад-Шивээхүрэн чиглэлийн (530 км урттай) төмөр замд илүү ач холбогдол өгч зүүн чиглэлийн төмөр замаас цаг хугацааны хувьд түрүүлэн, ирэх 2024-2027 онуудад барьж байгуулах шаардлагатай байна.

Өрнөдийн орнуудын зүгээс ОХУ-ын газрын тосны үнийн дээд хязгаарыг тогтоож, энэ оны 2-р сараас эхлэн Европын Холбооны гишүүн орнууд ОХУ-аас газрын тос, нүүрс худалдан авахгүй байх, шатдаг хийн импортыг ихээхэн бууруулахаар тогтоосон. Үүний улмаас ОХУ-ын төсвийн орлого эхний 2 сард 30 гаруй хувиар тасалдаж, төсвийн алдагдал нь ихээхэн нэмэгдэж байна.

Гадаад эдийн засгийн орчин, геополитикийн эрсдэл Монгол улсад хэрхэн нөлөөлж болзошгүй вэ:

Нэгд. Өрнөдийн орнуудын болон ОХУ-ын зүгээс тогтоосон хориг арга хэмжээний улмаас Европын улс орнуудаас ОХУ-

ын нутгаар транзит ачаа тээвэрлэх боломжгүй болсон. Иймд Европын орнуудаас авах импортын ачаа барааг Турк болон Төв Азийн зарим улс орны нутгаар л дамжуулан авах боломжтой, энэ нөхцөлд тээвэрлэлтийн зардал, цаг хугацаа нэмэгдэх эрсдэлтэй болсон.

Хоёрт. Мөн Украины дайн, хориг арга хэмжээний улмаас Монгол улсын агаарын орон зайгаар дамжин өнгөрөх олон улсын нислэг эрс буурсан.

Гуравт. ОХУ-ын зүгээс Европын зах зээлд гаргаж байсан газрын тос, нүүрс, шатдаг хийг БНХАУ, Энэтхэг улсын зах зээлд илүү ихээр гаргах болсон. Өнгөрсөн 2022 онд ОХУ-аас БНХАУ-д 20.0 сая орчим тн коксжих нүүрс нийлүүлсэн гэсэн мэдээлэл байна. Цаашид ОХУ-аас БНХАУ-ын нүүрсний зах зээлд орон зайгаа нэмэгдүүлэх нь Монгол улсын нүүрсний экспортын орон зайг шахах эрсдэлийг өсгөж байна.

Дөрөв. Монгол улс -ОХУ-ын хилийн боомтоор дамжих ачаа тээвэр, худалдаа эрс буурсан тул манай улсын импортын ачаа бараа бүхэлдээ Тяньжин, Замын-Үүд боомтоор дамжин орж ирэх ганцхан гарц үлдэж байна. Хэрэв цаашид Тайваний хоолойн зөрчлийн улмаас БНХАУ-АНУ-ын хоорондын зөрчил хурцадвал Бохайн булангаар дамжин өнгөрөх далайн тээвэрлэлт түр саатах, гацах, тээвэрлэлтийн өртөг зардал нэмэгдэх эрсдэлтэй.

Дүгнэлт:

Дэлхий нийтээр геополитикийн болон бусад шалтгааны улмаас бүхий л талын эрсдэл нэмэгдэж

байгаа тул Монгол улсын хувьд эдийн засгийн өсөлтөө хадгалж, гадаад худалдааг эрсдэлд оруулалгүй авч үлдэхийн тулд:

1. Хилийн боомтын хүчин чадлын нэмэгдүүлэх, Тавантолгой-Гашуунсухайт, Зүүнбаян-Хангийн чиглэлийн төмөр замын холболтыг аль болох богино хугацаанд хийж гүйцэтгэх, ашиглалтад оруулах,

2. Нүүрсний экспортыг цаашид бууруулалгүй, өнгөрсөн 2022 онд хүрсэн түвшнээс бууруулалгүй хадгалахын тулд БНХАУ-ын худалдан авагч талтай худалдааны нөхцөлийн талаар сайтар ярьж ойлголцож байх, түүхий эдийн биржийн худалдааны талаар БНХАУ-ын худалдан авагч компаниудтай сайтар ойлголцож ажиллах,

3. Замын Үүд-Эрээний ганц боомтод гадаад худалдааны томоохон хувь төвлөрч байгаа эрсдэлийг цаашид бууруулахын тулд Шивээхүрэн-Сэхэгийн боомтын дэд бүтцийг сайжруулах, Сэхэ боомтоор импортын ачаа бараа авах нөхцөлийг бүрдүүлэх, Шивээхүрэн-Даланзадгад чиглэлийн автозамыг засаж сайжруулах, өргөтгөх арга хэмжээг 2023-24 онуудад хэрэгжүүлэх,

4. Төмөр замын талаар баримтлах бодлогод тусгагдсан Даланзадгад-Шивээхүрэн чиглэлийн (530 км урттай) төмөр замд илүү ач холбогдол өгч зүүн чиглэлийн төмөр замаас цаг хугацааны хувьд түрүүлэн, ирэх 2024-2027 онуудад барьж байгуулах шаардлагатай байна.



**Ж.Баттогтох**  
ОУХНУС-ийн профессор.

## ОРОС-ӨРНӨДИЙН ӨРСӨЛДӨӨН, ОЛОН УЛСЫН ЭРХ ЗҮЙН ҮЙЛЧЛЭЛД

Олон улсын харилцааны түүх улс орнууд өөр хоорондоо ямар нэг дэг журамгүйгээр, хүчээр сөргөлдөх эсхүл өнөө маргаашаа аргаахаа маягаар оршин тогтнох боломжгүйг харуулдаг. Дэлхийн улс орнуудад хууль цаазын үндэс суурь бүрэлдэн тогтож ирсэнтэй харьцуулахад улс хоорондын харилцааны зохицуулалтын эрх зүйн системийн бүрдэл нь олон улсын эрх зүйн цогц институт болтлоо илүү нарийн ээдрээтэй замыг туулж ирсэн ба олон улсын харилцааг зохицуулж, тэдгээрийг олон улсын эрх зүйн харилцаа болгодог хуулийн зарчим ба хэм хэмжээнүүдийн нэгдлийн хувьд, олон улсын дэг журмын үндэс нь болсоор байна.

1990-ээд оны эхээр социалист систем задарч, коммунист онолын чиг баримжаа бүхий эрх баригчид улс төрийн үзэл суртлаа алдсан нь янз бүрийн улс орнуудын хоёр талын болоод олон талын харилцаанд эргэлт гарах шалтгаан болсон билээ. Олон улсын харилцаа өнгөрсөн зууны сүүлийн хагасын хоёр туйлт үеийнхээс эрс өөрчлөгдөж, хөгжлийн шинэ том төвүүд бий болж, олон улсын харилцаанд тэдгээрийн үзүүлэх нөлөө өсөх хандлагатай байна.

Олон улсын эрх зүйн зохицуулалт нь олон улсын харилцааны шинэ хүрээ, салбарт тархаж, өмнө нь үндэсний эрх зүйн зохицуулалтын хүрээнд багтдаг байсан хүний эрх, эдийн засгийн зарим салбар төдийгүй мэдээлэл, шашин зэрэг асуудлыг хамрах болжээ.

Олон улсын харилцааны тодорхой асуудлуудыг олон улсын эрх зүйгээр зохицуулах шаардлага бий болсноор олон улсын эрх зүйн шинжлэх ухаан эрчимтэй хөгжиж эхлэв. Өмнө нь улсууд дангаараа ашиг сонирхлоо хамгаалах бодлого баримталдаг байсан бол өнөөдөр хамтын хүчээр олон улсын эрх зүйг хэрэглэх хандлага бий болсон.

Орчин үеийн буюу өнөөгийн олон улсын эрх зүйг Орос-Өрнөд гэсэн 2 хүчний сөргөлдөөн гэж үзвэл энэ нь өнөөдөр НҮБ-ийн Аюулгүй Зөвлөл дээр үргэлжилж байна. НҮБ бол 2 Орос-Өрнөд гэсэн 2 ертөнцийг холбож байна. Эндээс их гүрнүүдийн зөрчилдөөн НҮБ-ын Дүрмийг зөрчих, өөр өөрийн эрх ашгийн үүднээс тайлбарлах болон хэрэглэх байдлаар зөрчил, мөргөлдөөн үргэлжилж буйг бид орос-украиний хямрал дээр харж байна. Дэлхийн түүхэнд 20, 21 дүгээр зуунд 250 гаруй удаа олон улсын эрх зүйн үндсэн зарчмуудыг зөрчсөн дайн болсон байна. Энэ үед мөн л Орос-Өрнөд сөргөлдөж улс орнуудын хөгжлийн хурд, төвшин улам бүр ялгаатай болж, буурай, эмзэг эдийн засагтай улсуудад ядуурал буурахгүй, бүс нутгийн мөргөлдөөн хямрал багасахгүй, зарим улс, бүс нутагт цөмийн зэвсэгтэй болох оролдлого үргэлжилж, хурцадмал байдал даамжирсаар байгаа төдийгүй уур амьсгалын өөрчлөлт, байгаль орчны доройтол хийгээд олон улсын терроризм, хүний

болоод хар тамхины наймаа, гоц халдварт өвчний тархалт зэрэг аюул занал нэмэгдэж байсан.

Украиныг тойрсон олон улсын эрх зүйн хямрал 2014 оноос эхлэлтэй. Энэ үед хүний эрхийг бүх нийтээр хүндэтгэх, улсын дотоод хэрэг үл оролцох, улс бүр өөртөө засан тогтнох эрх зэрэг олон улсын эрх зүйн хэм хэмжээ, зарчим удаа дараа зөрчигдөж байв. Эндээс олон улсын эрх зүй хаашаа, хэрхэн цаашид хөгжих вэ гэдэг түгээмэл асуултууд зөвхөн Орос-Украины хямралаас болж үүсээгүй болно. Олон улсын эрх зүйн хөгжил, төлөвшил ямар үе шатандаа явж буйг өнөөгийн Орос-Украины хямрал тод томруунаар л харуулж өгсөн юм. Олон улсын эрх зүйн тулгамдсан асуудлуудын нэг бол бүх улс олон улсын эрх зүйн үндсэн зарчмуудыг бүх нийтээрээ заавал, үг дуугуй дагаж мөрдөх ёстой үүрэг хүлээсэн атал уг императив хэм хэмжээг биелүүлэхгүй байх явдал ихсэх болсонд асуудлын мөн чанар оршино. Улс гүрэн олон улсын эрх зүйн хүрээнд олон улсын өмнө хүлээсэн үүргээ биелүүлэхгүй явдлаа дотоодын хууль тогтоомжтойгоо холбон зөвтгөх эрхгүй байдаг. Өөрөөр хэлбэл, тухайн улс нэгдэн орсон олон улсын гэрээний хэм хэмжээний дээгүүр үндэсний эрх зүйн хэм хэмжээгээ тавих эрхгүй.

Мөн хэдий улс орнууд олон улсын эрх зүйн хүрээнд тэгш эрхтэй гэж НҮБ тунхагласан ч



улс төр, эдийн засагт гүйцэтгэх тэдний үүрэг, эзлэх байр суурь харилцан адилгүй болж ирсэн. Олон улсын эрх зүй нь анхнаасаа л үр нөлөөгүй, ялгавартай, хуулийн цоорхойтой болон шударга бус үйлчилэлтэй байж ирсэн нь өнөөгийн дэлхий

ертөнцийн ярвигтай байдлыг бий болгосон гэж олон улсын эрх зүйн шинчээчид үздэг. Их гүрнүүд олон улсын эрх зүйг хэрэгтэй үедээ ашиглаад, хэрэггүй, саад болсон үедээ хойш тавьдаг зүй тогтол нь олон улсын харилцааны бичигдээгүй

хууль болжээ. Энэ бүхэн нь олон улсын эрх зүй нь илүү үр дүнтэй зохицуулалт, түүний зарим институцуудад шинэ хандлага, уур амьсгал оруулахыг зүй ёсоор шаардаж байна.





Ж.Гэлгее

Олон улсын харилцааны судлаач

## ОЛОН УЛСЫН ХОРИГ БА ОРОСЫН ЭДИЙН ЗАСАГ

ОХУ нь 2022 оны байдлаар дэлхийн 11 дэх том эдийн засаг болсон. Эрдэс, түүхий эдийн худалдаанаас Оросын эдийн засаг нэн хамааралтай юм. Зөвхөн Европын Холбоо гэхэд Оросын эсрэг 10 багц арга хэмжээг авч, АНУ болон бусад улс орнууд мөн хориг арга хэмжээ авч байгаа. Их 7, ЕХ, зарим тохиолдолд Сингапур зэрэг улсууд багтаж байгаа. 2014 оны хориг одоо ч үргэлжилж байгаа шиг энэ дайн дууссан ч гэсэн эдгээр хориг цаашид үргэлжлэх юм. Хоригууд нь ОХУ-ын эдийн засгийг боомилох, эрчим хүчний хүндрэл бий болгох гэх мэтчилэн олон төрлүүд байна. Оросын банкууд олон улсын чөлөөт банкны сүлжээнээс үндсэндээ хасагдсан. Оросын төв банкны нийт активын хагас орчим нь гадаадад царцсан байдалтай байна. Дайнаас өмнө Оросын ДНБ таван хувиар өснө гэж төсөөлж байсан бол эсрэгээрээ хоёр хувиар буурч том уналт үзүүлсэн. Инфляци мөн өссөн үзүүлэлттэй байгаа. Оросын эдийн засаг төдийлөн алдагдалд ордоггүй байсан бол ДНБ-ий 2,5 хувиар алдагдалтай гарсан байна. Төв банк бодлогын хүүг дөрвөн хувьд хүргэж, дотооддоо валютын арилжааг үндсэндээ зогсоосон. Баялгийн сангийнхаа j-ийг ашиглаж, ААН-үүдийн валютын нөөцийн 80%-г албадан авсан зэрэг үйлдлүүдийн үр дүнд рублийн ханш төдийлөн өөрчлөгдөөгүй. Хориг арга хэмжээнүүдийн удаашралтай байдал Оросын нефть, хийн орлого огцом унахгүй байхад

нөлөөлсөн. Түүнчлэн Европ руу явж байсан нийт нефть, хийн s нь Хятад, Энэтхэг зэрэг Азийн бүсэд шилжсэн.

Цаашид 2023 оны төсөв хоёр хувийн алдагдалтай батлагдсан. Үүнээс төсвийн 27 хувь нь батлан хамгаалах зардал гэж ойлгосон. Дэлхийн банк ДНБ-ий хэмжээг гурваас таван хувиар унана гэсэн төсөөлөлтэй байгаа бол ОУВС нэг хувь орчим унана гэсэн өөр өөр үзүүлэлт байна. Энэ жилээс эхлэн Өрнөдийн орнуудын хориг арга хэмжээ Орост нэлээн хүчтэй дарамт үзүүлэх болов уу. Оросоос авч байгаа зарим зүйлсийн татварыг 25 хувь, 30 хувь гэх мэтээр өсгөж байгаа. Үүнээс гадна Ази, Хятад, Энэтхэг рүү өгч байгаа нефть далайгаар явж байгаа учраас тээврийн зардал нь мөш өндөр. Ийм учраас нефтийн орлого буурахын хажуугаар ямар нэг байдлаар алдагдалтай буюу экспортын валют орлоо ч гэсэн яг дотоодын өртөг зардал алдагдалтай байх магадлалтай. Үүнээс гадна энэ хоригтой холбогдоод Орос руу гадаадын шууд хөрөнгө оруулалт орохоо больж байна. Өнгөрсөн онд гэхэд нийтдээ 80 орчим тэрбум долларын хөрөнгө Оросоос гарсан. 1000 орчим ААН гарлаа. Мкдоналдсаас эхлээд бүх төрлийн компани Оросыг орхиж гарсан. Мэдээж хэрэг, хоригтой холбогдоод өрнөдийн хөрөнгийн зах зээлд оролцох, зээллэг авах, криптовалютын үйлчилгээнд орох зэргээр Оросын оролцоо Европ, Америкт хаагдаж байна. Металлургийн салбараас хамаараад 5-6 тэрбум,

нүүрсээс хамаараад 17 тэрбумын Европд хийж байсан экспорт үгүй болсон.

Хамгийн хүнд салбар бол иргэний нисэхийн салбар болж байх шиг байна. Оросод ашиглаж байсан нийт онгоцны 95% нь Европ, Америкт үйлдвэрлэсэн. Тэд нь сэлбэг муутай болж зарим онгоцыг задлан аргацааж байгаа байдал ажиглагдаж байна. ЕХ бол өндөр технологийн тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгслийг Орос руу 32 тэрбумаар экспортолж байсан бол тэрийгээ хаасан. Оросын эмийн үйлдвэрлэл төвөгтэй болсон байна. Учир нь 80% нь түүхий эдээ авч байсан. Энэ хориг бүрэн хэрэгжиснээр хүндрэл үүснэ. Гэвч Оросын эдийн засаг сүйрнэ гэсэн үг биш. Дунд болон урт хугацаандаа өсөлт нь саарна. Улмаар тэргүүлэх орнуудаас технологийн салбарт үлэмж хоцроно. Дайны зардал бараг энэ онд үргэлжлээд 2024 онд 2 дахин өслөө гэж бодоход Оросын ДНБ-ны 5-6%-иас хэтрэхгүй. 2022 оны байдлаар 2%-тай тэнцэж байсан. Өөрөөр хэлбэл хоригууд бол мөргөлдөөнийг зогсоох цорын ганц арга биш. Хориг тавилаа ч гэсэн дайныг бүрэн зогсоох хүчин зүйл болж чадахгүй. Эцэст нь тэмдэглэхэд, царцаасан хөрөнгийн асуудал нэлээд төвөгтэй байгаа. Жишээ нь, “Вагнер” группийн гадаадад царцаасан хөрөнгийг Украйны сэргээн босголтод зарцуулна гээд Канадууд өөрсдөө орлуулаад зарцуулах юм шиг ойлголт төрсөн. Энэ нь олон улсын эрх

зүйн талаас нэлээд төвөгтэй. Түүрүүн дурдсанчилан Оросын албан ёсны валютын нөөц нь царцсан байгаа. Энийг хэзээ яаж суллах вэ гэдэг нэлээд төвөгтэй. Түүнээс гадна Орост орсон компаниудын хөрөнгийг

Оросууд царцаасан. Оросоос бол ашгаа хөрвүүлэх бусад үйл ажиллагаанд оролцохыг хориглосон байгаа. Эдийн засгийн маш том дайн болж байна. Царцаасан хөрөнгө, хураагдсан хөрөнгийн асуудал

нь дараагийн маш том маргаантай асуудал, олон улсын харилцааны зайлшгүй зохицуулах том асуудал болохнээ гэж бодож байна.



## МУИС-ИЙН ОУХНУС-ИЙН ХҮНДЭТ ТӨГСӨГЧ, ГАДААД ХАРИЛЦААНЫ САЙД Б.БАТЦЭЦЭГ ОЮУТНУУДАД ЛЕКЦ УНШЛАА

2023 оны 4 сарын 24-нд ОУХНУС-ийн “Хүндэт төгсөгчийн индэр”-ийн анхны зочин Монгол улсын Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг “Монгол улсын гадаад бодлого, дипломат ажиллагаа” сэдвээр оюутан залууст лекц уншлаа. “Transforming Education” хэмээх XXI зууны дэлхийн улсуудын боловсролын салбарыг бүхэлд нь хамран өрнөж буй өөрчлөлт шинэчлэлийн үйл явц МУИС-д эрчимжсэн цаг үед “Хүндэт төгсөгчийн индэр” арга хэмжээ нь оюутан суралцагчдад чиглэсэн зорилтот үйл ажиллагаа болж буйн хувьд шинэлэг юм.

МУИС-ийн захирал Д.Бадарч арга хэмжээг нээж үг хэлэхдээ сүүлийн гуч гаруй жилд МУИС-ийн Олон улсын харилцаа, нийтийн удирдлагын сургууль үндэсний түвшинд танигдаж, эх орныхоо хөгжил дэвшилд 4000 гаруй төгсөгчид нь мэдлэг, чадвар, манлайллаараа бодит хувь нэмэр оруулж буйн тод илрэл нь 1996 оны МУИС-ийн Олон Улсын Харилцааны дээд

сургуулийн төгсөгч, Монгол улсын Гадаад харилцааны сайд Батмөнхийн Батцэцэг болохыг онцлов.

Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг өөрийн илтгэлдээ өнгөрсөн 30 гаруй жилийн хугацаан дах манай улсын гадаад бодлогын ололт амжилт болон цар тахлын сөрөг нөлөө, олон улсын нөхцөл байдал эдрэрэтэй, геополитикийн зөрчил хурцдаж, хориг арга хэмжээ даамжирч буй энэ эгзэгтэй үед Монгол Улсын гадаад харилцаандаа баримталж буй бодлого чиглэл, хийж хэрэгжүүлж буй ажил, олон улсын харилцаа, хамтын ажиллагаатай холбоотой асуудлыг тоймлон танилцуулсан.

ОУХНУС-ийн захирал Ж.Баттогтох Хүндэт төгсөгч Б.Батцэцэгт төрөлх сургуулийнхаа урилгыг хүлээн авч, оюутан залууст сонирхолтой лекц уншиж, үнэтэй сургаал зөвлөмж өгсөнд талархлаа илэрхийллээ.

Дэлхийн тэргүүлэх их дээд сургуулиуд хувийн амжилтаар

Их сургуулийнхаа нэр хүндийг өндөрт өргөж яваа, академик орчинд, нийгэмдээ, олон улсад, мэргэжлийн салбартаа ололт амжилт гаргасан, соёл нийгмийн амьдралд гарамгай онцгой гавьяа байгуулсан зэрэг шалгуураар төгсөгчдөөсөө шалгаруулан The Distinguished Alumnus, The Outstanding Alumnus зэрэг эрхэм цолыг хүртээж, алдаршуулдаг. Энэ нь төгсөгч-их сургууль-суралцагч-багш профессорууд хэмээх олон талт харилцааны эргэх холбооны чухал илрэл болж байдаг.

ОУХНУС эрхэм зорилгынхоо хүрээнд цаашид Төгсөгчдийн холбоотой хамтран салбартаа хүлээн зөвшөөрөгдсөн, нийгэмд мэдлэг, ур чадвар, хандлагаараа манлайлагч, сургуулийнхаа бахархал болсон шилдэг төгсөгчийг жилд нэг удаа алдаршуулах “Хүндэт төгсөгчийн индэр” арга хэмжээг зохион байгуулж, оюутан залууст урилгаар лекц уншуулж үйл ажиллагааг тогтмолжуулах юм.

